

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинжлэх Ухааны Академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2025/019/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Аудитор: Т.Баасанцэнд
Утас: 261628 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn
Аудитор: Г.Тэлмүүн
Утас: 261628 Цахим хаяг: telmuung_@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	14
3.4.2 Авлага.....	15
3.4.3 Урьдчилгаа.....	15
3.4.4 Бараа материал.....	15
3.4.5 Үндсэн хөрөнгө.....	16
3.4.6 Өр төлбөр.....	17
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо.....	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	22
4.1 Ерөнхий зүйл.....	22
4.2 Материаллаг байдал.....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	25
5.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	25
5.2 Харьяа байгууллагууд.....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогийн баримт бичиг
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогийн албан татвар
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТСан	Шинжлэх ухаан, технологийн сан
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 801
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинжлэх Ухааны Академийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинжлэх Ухааны Академийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 297, 732, 815 дугаар тогтоолуудын дагуу нийт 722 нэр төрлийн, 4,579.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 3,017.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоон санхүүгийн тайланд бүртгэсэн, мөн 309, 862, 896 дугаар тогтоолуудын дагуу нийт 646 нэр төрлийн, 1,069.8 сая төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, акталсан байна.

Аудитын гол асуудал

Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд гадаадын болон дотоодын байгууллагуудтай хамтарсан төсөл хэрэгжүүлж нийт 11,759.1 сая төгрөгийн төсвийн бус орлого бүрдүүлсэн байна. Дээрх орлогоос төслийн үйл ажиллагаа, судалгааны ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд 8,879.6 сая төгрөгийг зарцуулж, 2,879.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 2,804.5 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг Сангийн яамны Төрийн сангийн газартай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,694,131.5	5,630,609.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	399,367.0	11,561.4
33	АВЛАГА	2,259,691.3	2,865,221.3
34	УРЬДЧИЛГАА	216,346.7	20,694.7
35	БАРАА МАТЕРИАЛ	2,818,726.5	2,733,132.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	50,031,450.8	59,612,004.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	50,031,450.9	59,612,004.1
39200	Биет хөрөнгө	40,242,661.3	49,809,412.5
39300	Биет бус хөрөнгө	9,788,789.6	9,802,591.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (3=1+2)	55,725,582.3	65,242,613.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,676.2	89,575.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,676.2	89,575.0
41300	Өглөг	17,676.2	89,575.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН	55,707,906.1	65,153,038.6
51	Засгийн газрын хувь оролцоо	55,707,906.1	65,153,038.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	23,421,829.7	23,423,573.3
51200	Хуримтлагдсан үр дүн	21,895,533.1	31,341,862.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,390,543.4	10,387,603.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН (6=4+5)	55,725,582.3	65,242,613.6

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	63,123,131.5	75,285,090.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,123,131.5	75,285,090.8
120	Нийтлэг татварын бус орлого	4,718,407.6	11,491,846.6
122	Тусламжийн орлого	6,504,247.8	63,793,244.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,900,476.1	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	55,338,502.4	65,574,476.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,338,502.4	65,574,476.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,548,078.7	61,716,237.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,210,695.5	39,039,907.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,095,346.8	4,646,645.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	850,757.7	958,694.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,369,738.1	1,462,485.2
2105	Нормативт зардал	221,096.7	525,560.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	894,107.9	598,280.6
2107	Томилолт, зочны зардал	2,379,932.0	2,603,545.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,988,658.8	4,990,800.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,537,745.2	6,890,318.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	790,423.7	3,858,238.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,784,629.1	9,710,614.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	123,932.8	185,794.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(V)	7,660,696.3	9,524,820.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	61,769,505.8	65,991,099.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,487,582.9	65,991,099.4
120	Нийтлэг татварын бус орлого	983,335.1	885.0
122	Тусламжийн орлого	6,504,247.8	65,990,214.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	54,281,922.9	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,993,159.3	62,520,943.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,993,159.3	62,520,943.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,003,778.7	55,858,134.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,220,472.1	39,023,382.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,099,246.7	4,665,349.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	853,673.5	957,667.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,535,201.4	1,295,723.8
2105	Нормативт зардал	537,590.5	641,536.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,051,280.6	750,047.2
2107	Томилолт, зочны зардал	2,549,569.3	2,663,133.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,316,288.9	5,079,831.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	840,455.7	781,462.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,989,380.6	6,662,808.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,776,346.5	3,470,155.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	7,376,979.5	3,857,961.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,376,979.5	3,857,961.4
2200	Дотоод эх үүсвэрээр	7,376,979.5	3,857,961.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(7,376,979.5)	(3,857,961.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	399,367.0	(387,805.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	399,367.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	399,367.0	11,561.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,421,829.7	10,336,995.0	14,234,836.8	47,993,661.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,421,829.7	10,336,995.0	14,234,836.8	47,993,661.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	53,548.4	-	53,548.4
Тайлант үеийн үр дүн	-	-	7,660,696.3	7,660,696.3
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,421,829.7	10,390,543.4	21,895,533.1	55,707,906.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(78,491.3)	(78,491.2)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,421,829.7	10,390,543.4	21,817,041.8	55,629,414.9

Шинжлэх Ухааны Академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(2,940.2)	-	(2,940.2)
Өмчид гарсан өөрчлөлт	1,743.6	-	-	1,743.6
Тайлант үеийн үр дүн	-	-	9,524,820.3	9,524,820.3
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	23,423,573.3	10,387,603.2	31,341,862.2	65,153,038.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	53,236,657,500.00	48,490,247,038.25	4,746,410,461.75	91.1
Татварын бус орлого	53,236,657,500.00	48,490,247,038.25	4,746,410,461.75	91.1
Тусламжийн орлого	53,236,657,500.00	48,490,247,038.25	4,746,410,461.75	91.1
Төсвөөс санхүүжих	53,236,657,500.00	48,490,247,038.25	4,746,410,461.75	91.1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,236,657,500.00	48,490,247,038.25	4,746,410,461.75	91.1
УРСГАЛ ЗАРДАЛ	53,236,657,500.00	48,490,247,038.25	4,746,410,461.75	91.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,209,786,200.00	47,801,029,821.97	4,408,756,378.03	91.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,213,452,700.00	34,624,119,226.87	2,589,333,473.13	93.0
Үндсэн цалин	20,361,339,900.00	22,022,528,996.38	(1,661,189,096.38)	108.2
Нэмэгдэл	9,823,390,700.00	6,642,502,181.15	3,180,888,518.85	67.6
Унаа хоолны хөнгөлөлт	4,712,020,900.00	3,822,806,628.53	889,214,271.47	81.1
Урамшуулал	2,298,310,500.00	2,075,071,184.30	223,239,315.70	90.3
Гэрээт ажлын хөлс	18,390,700.00	61,210,236.51	(42,819,536.51)	332.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,646,450,100.00	4,124,511,696.15	521,938,403.85	88.8
Тэтгэврийн даатгал	3,128,427,000.00	2,836,984,861.64	291,442,138.36	90.7
Тэтгэмжийн даатгал	380,035,100.00	346,038,616.18	33,996,483.82	91.1
ҮОМШӨ-ний даатгал	191,438,400.00	178,796,148.84	12,642,251.16	93.4
Ажилгүйдлийн даатгал	189,268,900.00	152,233,156.96	37,035,743.04	80.4
Эрүүл мэндийн даатгал	757,280,700.00	610,458,912.53	146,821,787.47	80.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,065,997,700.00	933,065,762.16	132,931,937.84	87.5
Гэрэл, цахилгаан	585,996,700.00	522,061,481.09	63,935,218.91	89.1
Түлш, халаалт	344,997,700.00	297,704,418.33	47,293,281.67	86.3
Цэвэр, бохир ус	100,297,300.00	94,605,362.74	5,691,937.26	94.3
Байрны түрээс	34,706,000.00	18,694,500.00	16,011,500.00	53.9
Хангамж, бараа материалын зардал	819,687,900.00	754,890,138.48	64,797,761.52	92.1
Бичиг хэрэг	70,492,800.00	67,844,746.03	2,648,053.97	96.2
Тээвэр, шатахуун	23,348,600.00	22,729,558.00	619,042.00	97.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	79,823,500.00	62,488,897.75	17,334,602.25	78.3
Ном, хэвлэл	453,822,000.00	441,303,035.26	12,518,964.74	97.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,929,800.00	10,900,320.00	14,029,480.00	43.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	167,271,200.00	149,623,581.44	17,647,618.56	89.4
Нормативт зардал	191,126,500.00	163,054,260.00	28,072,240.00	85.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	182,636,900.00	155,645,760.00	26,991,140.00	85.2

Шинжлэх Ухааны Академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,489,600.00	7,408,500.00	1,081,100.00	87.3
Эд хогшил, урсгал засварын зардал	2,894,350,400.00	2,733,586,134.92	160,764,265.08	94.4
Багаж, техник, хэрэгсэл	2,159,460,000.00	2,042,986,656.88	116,473,343.12	94.6
Тавилга	49,420,000.00	49,365,665.00	54,335.00	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	141,614,500.00	110,841,410.92	30,773,089.08	78.3
Урсгал засвар	543,855,900.00	530,392,402.12	13,463,497.88	97.5
Томилолт, зочны зардал	622,182,000.00	606,366,326.55	15,815,673.45	97.5
Гадаад албан томилолт	76,710,500.00	74,015,335.45	2,695,164.55	96.5
Дотоод албан томилолт	521,684,700.00	508,614,175.00	13,070,525.00	97.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	23,786,800.00	23,736,816.10	49,983.90	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,295,250,700.00	3,418,646,909.64	876,603,790.36	79.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,900,446,000.00	3,268,247,060.64	632,198,939.36	83.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	63,662,500.00	26,000,000.00	37,662,500.00	40.8
Даатгалын үйлчилгээ	8,470,600.00	2,706,696.00	5,763,904.00	32.0
Тээврийн хэрэгслийн татвар	4,426,700.00	3,104,212.00	1,322,488.00	70.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,200,200.00	221,784.00	978,416.00	18.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,545,300.00	79,710,247.00	118,835,053.00	40.1
Газрын төлбөр	118,499,400.00	38,656,910.00	79,842,490.00	32.6
Бараа үйлчилгээний бусад зардал	461,288,200.00	442,789,367.20	18,498,832.80	96.0
Бараа үйлчилгээний бусад зардал	82,208,300.00	75,771,861.00	6,436,439.00	92.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	379,079,900.00	367,017,506.20	12,062,393.80	96.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,026,871,300.00	689,217,216.28	337,654,083.72	67.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	22,427,700.00	10,346,395.00	12,081,305.00	46.1
Засгийн газрын гадаад шилжүүлэг	22,427,700.00	10,346,395.00	12,081,305.00	46.1
Бусад урсгал шилжүүлэг	1,004,443,600.00	678,870,821.28	325,572,778.72	67.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	96,937,200.00	69,721,000.00	27,216,200.00	71.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	847,072,000.00	575,241,421.28	271,830,578.72	67.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,434,400.00	33,908,400.00	26,526,000.00	56.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,260	1,957	303	86.6
БАЙГУУЛЛАГЫН ТОО	11	9	2	81.8

Шинжлэх Ухааны Академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн байгууллага	11	9	2	81.8
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,109	1,016	93	91.6
Удирдах ажилтан	17	20	(3)	117.6
Гүйцэтгэх ажилтан	935	850	85	90.9
Үйлчлэх ажилтан	157	146	11	93.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,109	910	199	82.1
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	956	773	183	80.9
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	153	137	16	89.5
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	31	22	9	71.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	31	22	9	71.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	11,759,150,239.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	11,759,150,239.48
122	Тусламжийн орлого	-	11,759,150,239.48
1221	Хандив тусламж /дотоод/	-	11,759,150,239.48
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,759,150,239.48
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,062,049,163.89
350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	49,566,662.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,200,883,449.35
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,446,650,964.24
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	8,879,682,470.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	8,879,682,470.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	8,853,845,470.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	2,149,156,117.28
210101	Үндсэн цалин	-	356,598,223.22
210102	Нэмэгдэл	-	41,392,586.90
210104	Урамшуулал	-	1,475,556.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,749,689,751.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	272,116,529.92
210201	Тэтгэврийн даатгал	-	272,116,529.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	22,237,184.77
210301	Гэрэл, цахилгаан	-	18,801,246.77

Шинжлэх Ухааны Академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	-	3,435,938.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	520,492,791.03
210401	Бичиг хэрэг	-	45,795,635.00
210402	Тээвэр, шатахуун	-	177,911,105.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	479,000.00
210404	Ном, хэвлэл	-	182,854,271.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	113,452,780.03
2105	Нормативт зардал	-	479,481,810.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	479,481,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	671,363,937.19
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	584,294,769.19
210602	Тавилга	-	43,005,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	31,089,968.00
210604	Урсгал засвар	-	12,973,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,923,708,255.86
210701	Гадаад албан томилолт	-	318,051,321.42
210702	Дотоод албан томилолт	-	1,589,375,500.44
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	16,281,434.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,471,773,813.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,460,061,472.20
210803	Даатгалын үйлчилгээ	-	381,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	1,945,876.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	9,160,852.00
210807	Газрын төлбөр	-	224,013.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	343,515,031.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,839,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	340,675,091.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	25,837,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	25,837,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	18,542,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,295,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	2,879,467,768.73
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(2,879,467,768.73)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(2,879,467,768.73)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн үйл ажиллагаа нь шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллагын хувьд монголын эрдэмтдийн төлөөллийг бүрэн хамруулж, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага арга зүйгээр хангахад чиглэж үйл ажиллагаагаа явуулдаг Монгол Улсын Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах;
- Шинжлэх ухаан, технологийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон дүгнэлт гаргах;
- Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөлд үнэлгээ өгөх, хянан магадалгаа хийх;
- Салбарын шинжлэх ухааны хөтөлбөр, чиглэл, түвшинд тогтоосон хугацаанд үнэлгээ, дүгнэлт өгөх;
- Эрдмийн зэрэг цолтой боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" гэж заасны дагуу Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн Б/01 дүгээр тогтоолоор томилогдсон ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дарга А.Баярбаатар нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд Шинжлэх ухааны академийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 17 хүрээлэнгийн санхүүгийн тайланг нэгтгэжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шинжлэх Ухааны Академи нь Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх Ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль, эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, төр засаг, аж ахуйн нэгж, байгууллага, салбарын болон хувийн секторын эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгавар;

- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан;

Шинжлэх ухааны академын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шинжлэх ухааны академи нь эрх зүйн статусын хувьд өөрийн удирдлага бүхий төсвийн байгууллага бөгөөд эрхэм зорилго, чиг үүргийнхээ дагуу харьяа судалгааны байгууллагуудыг арга зүй, зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус академи нь Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/113 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглахаар байгаа боловч тус академийн үйл ажиллагааны онцлогт таарахгүй байгаа тул Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинжлэх Ухааны Академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,511.2 сая төгрөгөөр буюу 17.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	399,367.0	11,561.4	(387,805.6)
Авлага	2,259,691.3	2,865,221.3	605,530.0
Урьдчилгаа	216,346.7	20,694.7	(195,652.0)
Бараа материал	2,818,726.5	2,733,132.0	(85,594.5)
Үндсэн хөрөнгө	50,031,450.8	59,606,129.3	9,574,678.5
Нийт хөрөнгө	55,725,582.3	65,236,738.7	9,511,156.4
Өр төлбөр	17,676.2	89,575.0	71,898.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	55,707,906.1	65,147,163.7	9,439,257.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	55,725,582.3	65,236,738.7	9,511,156.4

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн данс эцсийн үлдэгдэл 11.6 сая болж, өмнөх оноос 387.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	399,367.0	11,561.4	(387,805.6)
Төгрөг	399,367.0	11,561.4	(387,805.6)
Арилжааны банк дахь харилцах	399,367.0	11,561.4	(387,805.6)
Дүн	399,367.0	11,561.4	(387,805.6)

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 11.6 сая төгрөг нь Одон орон, геофизикийн хүрээлэнгийн арилжааны банкин дахь дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- **Археологийн хүрээлэн:** Тус хүрээлэн нь "Монгол, Байгаль, Өмнөд Сибирь ба Умард Хятадын эртний соёлууд" олон улсын эрдэм шинжилгээний хурлын оролцогчдын байрлах байрны зардлыг харьцуулалтын арга ашиглалгүй шууд худалдан авалтаар 87,640.0 мянган төгрөгийн санхүүжилтийг "Түмэн-Асарт" ХХК-д олгосон;
- **Биологийн хүрээлэн:** Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2025.04.04-ний өдрийн 1/122 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг зөрчиж эрдэмтэн нарийн бичгийн даргад 1,100.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон, ерөнхий нягтлан бодогчид 1 дүгээр улирлын урамшуулал 900.0 мянган төгрөг давхардуулан олгосон;
- **Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн:** Төрийн албаны цалингийн нэгдсэн системд бодогдсон албан хаагчдын цалингаас 131.9 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгаж, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн;
- **Газарзүй, Геоэкологийн хүрээлэн:** Нийгмийн даатгалын тайланг 792.0 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын тайланг 481.2 мянган төгрөг, нийт 1,273.2 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан;
- **Олон улс судлалын хүрээлэн:** Тус хүрээлэн нь тайлант оны 4-р улирлын Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүн бүрэн гараагүй байхад 11-р сард 19,125.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон;
- **Палентологийн хүрээлэн:** Тус хүрээлэн нь шууд худалдан авах аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж 1:5000, 1:10000 масштабтай нарийвчилсан зураг гүйцэтгүүлэх ажлыг Суваргын дэнж ХХК-тай 18,000.0 мянган төгрөг, Геоверс консалтинг ХХК-тай 17,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон;
- **Тэргүүлэгчдийн газар:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгуулагын төсвөөр 3,017.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан;
- **Хими, химийн технологийн хүрээлэн:** ХХОАТ-ын тухай хуулийн 23.1-т заасан хөнгөлөлтийг 34 ажилтанд 1,752.0 мянган төгрөгөөр илүү эдлүүлснээс татварыг мөн дүнгээр дутуу, 35 ажилтанд 938.0 мянган төгрөгөөр дутуу эдлүүлснээс татварыг мөн дүнгээр илүү тайлагнасан;
- **Хими, химийн технологийн хүрээлэн:** Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс 3,013.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй байна.
- **Хими, химийн технологийн хүрээлэн:** Анхан шатны баримтын бүрдлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн бүрэн бүрдүүлж, гэрээ, гэрээ дүгнэсэн акт болон бусад нотлох баримт иж бүрэн биш байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 2,865.2 сая төгрөг болж, өмнөх оноос 605.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	12,121.7	2,088.3	(10,033.4)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	14,291.2	14,291.2
Татаас санхүүжилтийн авлага	2,196,952.9	2,804,570.2	607,617.3
Бусад авлага	50,616.7	44,271.6	(6,345.1)
Байгууллагаас авах авлага	43,056.0	39,877.7	(3,178.3)
Хувь хүмүүсээс авах авлага	7,560.7	4,393.9	(3,166.8)
Дүн	2,259,691.3	2,865,221.3	605,530.0

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт авлагын 2,865,221.3 сая төгрөгийн үлдэгдлийн 2,804.5 сая төгрөг буюу 97.9 хувийг тайлант жилд үүссэн Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлага эзэлж байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 20.7 сая төгрөг болж, өмнөх оноос 195.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)
Урьдчилж гарсан зардал	80,204.8	-	(80,204.8)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	80,188.2	17,633.5	(62,554.7)
Томилолтын урьдчилгаа	55,953.7	3,061.3	(52,892.4)
Дүн	216,346.7	20,694.8	(195,651.9)

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл өмнөх оныхоос 195.6 сая төгрөгөөр буурсан байна. Түүх угсаатны зүйн хүрээлэн бараа материал бэлтгэх урдчилгаа 16.3 сая төгрөг, эрдэм шинжилгээний 3 ажилтны томилолтын дараа тооцоогоор 1.5 сая төгрөг, Палеонтологийн хүрээлэн шатахуун картын үлдэгдэл 0.3 сая төгрөг, Хими, химийн технологийн хүрээлэн томилолтын дараа тооцоогоор 1.6 сая төгрөг, Тэргүүлэгчдийн газар шатахууны картын үлдэгдэл 1.0 сая төгрөгийг тус тус бүртгэсэн байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 2,733.1 сая төгрөг болж, өмнөх оноос 85.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)
Тусгай зориулалттай материал	373,695.9	272,852.6	(100,843.3)
Бэлэн бүтээгдэхүүн	712,550.4	583,389.6	(129,160.8)
Бичиг хэргийн материал	69,135.6	80,549.9	11,414.4
Аж ахуйн материал	564,197.6	660,697.5	96,499.9
Сэлбэг хэрэгсэл	101,811.1	53,553.9	(48,257.2)
Түлш шатах тослох материал	15,873.5	9,535.2	(6,338.3)
Барилгын засварын материал	17,678.8	3,513.5	(14,165.3)
Бусад хангамжийн материал	963,543.6	1,068,799.7	105,256.1
Мал амьтад	240.0	240.0	-
Дүн	2,818,726.5	2,733,131.9	(85,594.6)

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор нийт 3,112.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1.8 сая төгрөгийн бараа хандиваар хүлээн авч, 86.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй

шилжүүлэн авч, 3.096.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, 145.0 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлж, 44.8 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Тайлант онд тусгай зориулалттай материал 489.7 сая төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 388.1 сая төгрөг, бичиг хэргийн материал 203.5 сая төгрөг, аж ахуйн материал 534.7 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 143.3 сая төгрөг, түлш, шатах тослох материал 512.4 сая төгрөг, барилгын засварын материал 28.5 сая төгрөг, хүнсний материал 1.0 сая төгрөг, бусад хангамжийн материал 810.9 сая төгрөг, нийт 3,112.1 сая төгрөгийн бараа материал худалдан авсан.

Тайлант онд доорх хүрээлэнгүүд нийт 86.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Үүнд:

- Одон орон, геофизикийн хүрээлэн нь 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн №239 тогтоолын дагуу үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан бөгөөд 110.0 мянган төгрөгийн материалыг нөөцөд бүртгэж, 1,961.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 861.1 мянган төгрөгийн шатахуун, 42,635.5 мянган төгрөгийн сэлбэгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч орлогод бүртгэсэн.
- Олон улс судлалын хүрээлэн нь 7.3 сая төгрөгийн 280 ширхэг ном, Чингис хааны өв соёлын хүрээлэнгээс 0.4 сая төгрөгийн 21 ширхэг номыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэсэн.
- Археологийн хүрээлэн нь 9.6 сая төгрөгийн 280 ширхэг номыг орлогод авч бүртгэсэн.
- Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь 17.8 сая төгрөгийн 280 ширхэг, 5.5 сая төгрөгийн 320 ширхэг номыг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэсэн нь гол нөлөөтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- *Биологийн хүрээлэн: Анхан шатны баримтын бүрдэлгүй 40,275.5 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдаж, санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан;*
- *Биологийн хүрээлэн: Эм, эмнэлэгийн хэрэгсэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй нэр бүхий аж ахуйн нэгжээс 891.0 мянган төгрөгийн эм урвалж худалдан авсан байна.*

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 59,606.1 сая төгрөг болж, өмнөх оноос 9,574.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)
Биет хөрөнгө	40,242,661.2	49,803,903.5	9,561,242.2
Барилга, байгууламж, орон сууц	26,449,343.8	26,155,284.5	(294,059.3)
Авто тээврийн хэрэгсэл	242,940.2	967,041.5	724,101.3
Машин, тоног төхөөрөмж	9,967,784.2	18,963,581.3	8,995,797.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	746,658.7	817,574.1	70,915.3
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,122,531.0	2,122,531.0	-
Бусад үндсэн хөрөнгө	400,514.0	450,577.5	50,063.5
Дуусаагүй барилга байгууламж	3,600.0	3,600.0	-
Ном	309,289.3	323,713.6	14,424.3
Биет бус хөрөнгө	9,788,789.6	9,802,225.7	13,436.1
Программ хангамж	90,170.3	522,808.7	432,638.4
Бусад биет бус хөрөнгө	9,698,619.3	9,279,417.0	(419,202.2)
Дүн	50,031,450.8	59,606,129.2	9,574,678.3

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд 3,858.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч орлогоор бүртгэсэн байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар 178.6 сая төгрөг, Философийн хүрээлэн 27.9 сая төгрөг, Хэл зохиолын хүрээлэн 16.8 сая төгрөг, Физик, технологийн хүрээлэн 23.8 сая төгрөг, Одон орон, геофизикийн хүрээлэн 1,052.9 сая төгрөг, Хими, химийн технологийн хүрээлэн 666.7 сая төгрөг, Газарзүй, геоэкологийн хүрээлэн 48.7 сая төгрөг, Олон улс судлалын хүрээлэн 5.1 сая төгрөг, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 49.8 сая төгрөг, Археологийн хүрээлэн 463.3 сая төгрөг, Биологийн хүрээлэн 345.9 сая төгрөг, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 477.8 сая төгрөг, Палеонтологийн хүрээлэн 260.0 сая төгрөг, Геологийн хүрээлэн 62.3 сая төгрөг, Математик, тоон технологийн хүрээлэн 128.9 сая төгрөг, Тархи, сэтгэл судлалын хүрээлэн 16.5 сая төгрөг, Технологийн Инкубатор 33.0 сая төгрөгийн хөрөнгө тус тус шинээр орлогод авч бүртгэсэн байна.

Тайлант онд хандив тусламжаар нийт 418.1 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан. Үүнд, Газар зүй, геоэкологийн хүрээлэн олон улсын цөмийн энергийн агентлагаас 412.2 сая төгрөгийн үнэ бүхий компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, Философийн хүрээлэн Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2025 оны 10-р сарын 24-ний өдрийн А/801 тоот захирамжаар 5.9 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, тавилга эд хогшлыг буцалтгүй тусламжаар хүлээн авч тус тус бүртгэсэн байна.

ШУА-ийн хэмжээнд тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 297 дугаар тогтоол, “Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 732 дугаар тогтоол, “Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 815 дугаар тогтоолуудаар нийт 722 нэр төрлийн 4,579.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 3,017.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд бүртгэсэн. Мөн тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 309 дугаар тогтоол, “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 862 дугаар тогтоол, “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 896 дугаар тогтоолуудаар нийт 646 нэр төрлийн 1,069.8 сая төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий эд хөрөнгийг данс бүртгэлээс хасаж акталсан нь үндсэн хөрөнгийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Одон орон, геофизикийн хүрээлэн: Хуучнаар БШУЯ-ны харьяанд байхад уг яамнаас гаргасан нэгдсэн НБББББ-ийг мөрдөж байсан ба энэ НБББББ-т "сургуулийн номын санд худалдаж авсан номыг "Номын фонд" гэсэн үндсэн хөрөнгийн дансанд анхны өртгөөр нь бүртгээнэ" гэснийг баримтлан номыг буруу ангилснаас гадна багцлан бүртгэсэн байна. 2024 оны 9 дүгээр сараас Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болсон ба НБББББ-д өөрчлөлт оруулж мөрдөж ажиллаагүй;
- Физик технологийн хүрээлэн: 41 нэр төрлийн 45 ширхэг үндсэн хөрөнгийг гадаад нэршлээр бүртгэсэн.

3.4.6 Өр төлбөр

Өглөгийн дансны үлдэгдэл 89.6 сая төгрөг болж, өмнөх оноос 71.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)
Ажилчидтай холбоотой өглөг	11,949.8	3,163.6	(8,786.2)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,650.0	2,402.6	752.6
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	985.0	985.0
Бусад өглөг	4,076.4	83,023.8	78,947.4
Байгууллагад төлөх өглөг	0.0	76,272.4	76,272.4
Хувь хүмүүст төлөх өглөг	4,076.4	6,751.4	2,675.0
Дүн	17,676.2	89,575.0	71,898.8

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант онд өглөгийн үлдэгдэл нэмэгдсэн нь төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас 2025 онд 07, 12 дугаар саруудад албан даалгаврыг хүргүүлсэнтэй холбоотой байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар 7.5 сая төгрөг, Философийн хүрээлэн 2.0 сая төгрөг, Хэл зохиолын хүрээлэн 3.8 сая төгрөг, Физик, технологийн хүрээлэн 0.07 сая төгрөг, Газарзүй, геоэкологийн хүрээлэн 2.0 сая төгрөг, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 5.5 сая төгрөг, Биологийн хүрээлэн 68.7 сая төгрөг, Технологийн Инкубатор 0.07 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

Өр төлбөр дансны үлдэгдлийн 76.7 хувь Биологийн хүрээлэнгийн Монгол орны археологийн нэн ховор олдворийн дээж материалд шинэ үеийн нуклодетийн дараалал тогтоох аргаар /NGS/ генийн дараалал тогтоох, гаплотипийг тогтоох, шинжилгээ судалгааны ажлын төлбөрийн үлдэгдэл Мед монгол ХХК-д 36.0 сая төгрөг, Монголын алт ХХК-ийн захиалгат төсөл болох "Хөхөлзөхийн говь" төслийн хүрээнд контент хийх ажлын үлдэгдэл төлбөр Шинэ цэнхэр дэлгэц ХХК-д 32.7 сая төгрөгийн үлдэгдэл байна.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 65,147.2 сая төгрөг болж, өмнөх оноос 9,439.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)
Засгийн газрын хувь оролцоо	23,421,829.6	23,423,573.2	1,743.6
Хуримтлагдсан үр дүн	21,895,533.1	31,335,987.3	9,440,454.2
Өмнөх үеийн үр дүн	14,234,836.8	21,817,041.9	7,582,205.1
Тайлант үеийн үр дүн	7,660,696.3	9,518,945.4	1,858,249.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,390,543.4	10,387,603.2	(2,940.2)
Дүн	55,707,906.1	65,147,163.7	9,439,257.6

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант оны үр дүн 9,518.9 сая төгрөг байгаа нь засгийн газрын хувь оролцооны өсөлтөд гол нөлөө үзүүлж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 71,941.6 сая төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 03/260 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 2,307.4 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 238.7 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 269.0 сая төгрөг, нормативт зардлыг 28.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 6,252.8 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 923.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3,796.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,453.9 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 22.6 сая төгрөгөөр бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 94.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 15,197.7 сая төгрөгөөр бууруулж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 56,743.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,507.3 сая төгрөгөөр бууруулж 53,236.6 сая төгрөг болгон тодотгосон байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 2,486.0 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 365.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 71.0 сая төгрөг, нормативт зардлыг 2.2 сая төгрөг, Эд хогшил, урсгал засварын зардлыг 98.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 612.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 23.5 сая төгрөгөөр бууруулж, хангамж, бараа материалын зардлыг 91.7 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 48.5 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 11.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 51,540.9 сая төгрөгийн санхүүжилт авч 48,490.2 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 3,050.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 48,490.2 сая төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 2,589.3 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 521.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 132.9 сая төгрөг, хангамжийн зардал 64.8 сая төгрөг, нормативт зардал 28.1 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 160.8 сая төгрөг, томилолт, зочны зардал 15.8 сая төгрөг, Бусдаар гүйцэтгүүлэх төлбөр хураамж 876.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 18.5 сая төгрөг, Засгийн газрын гадаад шилжүүлэг 12.1 сая төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардал 325.6 сая төгрөгөөр тодотгосон төсвөөс тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Хөтөлбөр арга хэмжээний нэр		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Код	Нэр				
70815	Шинжлэх ухаан технологи	53,236,657.5	48,490,247.0	4,746,410.5	91.1%
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	48,309,340.2	44,532,782.8	3,776,557.4	92.2%
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал	169,904.1	169,205.7	698.4	99.6%
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал	595,458.8	391,342.0	204,116.8	65.7%
80219	Харуул, хамгаалалтын зардал	900,521.7	765,871.3	134,650.4	85.0%
80220	Холбооны суваг ашигласны хөлс	343,828.0	334,730.6	9,097.4	97.4%
80226	Байр ашиглалтын үйлчилгээний зардал	497,177.5	296,533.1	200,644.4	59.6%
80509	Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	22,427.7	10,346.4	12,081.3	46.1%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	1,004,443.6	678,870.8	325,572.8	67.6%
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	1,393,555.9	1,310,564.3	82,991.6	94.0%

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад академын хүрээнд дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу Шинжлэх ухааны академийн харъяа

хүрээлэнгүүд нь зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалтныг цомхотгож ажиллаагүй байна.

Шинжлэх ухааны академийн харъя хүрээлэнгүүд тайлант онд холбогдох захирлын тушаалаар хоол, унааны хөнгөлөлтийг шинэчлэн тогтоосон байна. Үүнд:

- Биологийн хүрээлэн 36.0 мянган төгрөг;
- Археологийн хүрээлэн, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Математик тоон технологийн хүрээлэн, Олон улс судлалын хүрээлэн, ШУА-Тэргүүлэгчдийн газар, Геологийн хүрээлэн, Газарзүй, геоэкологийн хүрээлэн, Одон орон геофизикийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Технологийн инкубатор, Түүх угсаатны зүйн хүрээлэн, Физик технологийн хүрээлэн, Философийн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн 35.0 мянган төгрөг;
- Хими, химийн технологийн хүрээлэн, Тархи, сэтгэл судлалын хүрээлэн 17.5 мянган төгрөг.

Тайлант онд тус академийн харъяа хүрээлэнгүүд 471.2 сая төгрөгийн 69 хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 419.7 сая төгрөгийн 63 арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Мөн хүрээлэнгүүдийн хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 82.4 сая төгрөгийн 34 арга хэмжээг нэмэлт санхүүжилтийн данснаас санхүүжүүлсэн байна.

Шинжлэх ухааны академийн харъяа хүрээлэнгүүд нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 246.0 сая төгрөгийн 47 удаагийн гадаад томилолтыг төлөвлөж, гүйцэтгэлээр 224.4 сая төгрөгөөр 42 удаа гадаад томилолтоор, хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 142.8 сая төгрөгөөр 21 удаа томилтоор тус тус явсан байна. Хэрэгжсэн гадаад томилолтын 63 арга хэмжээ нь эрх бүхий этгээдээс баталсан тушаал, шийдвэртэй байна

Шинжлэх ухааны харъяа хүрээлэнгүүд нь шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний ололтыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 10 байгууллагатай 48.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 48.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Шинжлэх ухааны харъяа хүрээлэнгүүдийн данс бүртгэлд 691.9 сая төгрөгийн 29 программ хангамж бүртгэлтэй байгаагаас санхүү бүртгэлийн 18.6 сая төгрөгийн 15 программ, архив, албан хэрэг хөтлөлтийн 0.6 сая төгрөгийн 3 программ, видео бичлэг эвлүүлэх зориулалттай 4.1 сая төгрөгийн 2 программ, газар хөдлөлт бүртгэх, хянах, чичирхийлэлтэд анализ хийх 638.4 сая төгрөгийн 3 программ, оффисийн хэрэглээний 0.3 сая төгрөгийн 2 программ, Палеогистологийн тусгай зориулалттай 10.0 сая төгрөгийн 1 программ, Серверийн үйлдлийн системийн 11.4 сая төгрөгийн 1 лиценз, судалгааны 8.5 сая төгрөгийн 1 программ тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- *Биологийн хүрээлэн: Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй;*
- *Газарзүй, Геоэкологийн хүрээлэн: Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй мөн 2025 оны 8 дугаар сарын 01-нээс сул орон тоон дээр 9 хүн шинээр нөхөж ажилд томилсон;*
- *Хими, химийн технологийн хүрээлэн: Засгийн газрын 2024 оны 238 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор ТҮШУ-1 албан тушаалын цалингийн хэмжээ 1,283.0 төгрөг байхад байгууллага 1,500.0 мянган төгрөг ТҮШУ-2 1,484.0 мянган төгрөг байхад байгууллага 1,700.0 мянган төгрөг, ТҮШУ-3*

1,559.0 мянган төгрөг байхад байгууллага 1,800.0 мянган төгрөг, ТУШУ-4 1,637.0 байхад байгууллага 1,900.0 мянган төгрөгөөр тус тус тогтоож, шатлалын зарчмыг зөрчсөн;

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив тусламж 1,062.0 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 49.6 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,200.9 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,446.6 сая төгрөг, 11,759.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс төсөл хэрэгжүүлэгчийн цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалтай холбоотой зардалд 2,149.2 сая төгрөг, Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 272.1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 22.2 сая төгрөг, хангамжийн зардалд 520.5 сая төгрөг, нормативт зардалд 479.5 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 671.4 сая төгрөг, томилолтын зардалд 1,923.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2,471.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 343.5 сая төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардалд 25.8 сая төгрөг, нийт 8,879.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл нийт 2,879.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, үүнээс 2,804.6 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шинжлэх Ухааны Академийн харьяа хүрээлэнгүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоолын дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж зохион байгуулан ажилласан байна.

Шинжлэх Ухааны Академийн харьяа хүрээлэнгүүд нь тайлант хугацаанд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 13, харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар 25, шууд худалдан авалтын аргаар 3, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 1 тендер зохион байгуулахаар төлөвлөж 35 худалдан авах ажиллагааг зохион байгуулж үр дүн нийтэлсэн байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр 1,000.0 сая төгрөг, урсгал төсвөөс 805.3 сая төгрөг, Математик, тоон технологийн хүрээлэн урсгал төсвөөс 111.0 сая төгрөг, Хими, химийн технологийн хүрээлэн урсгал төсвөөс 435.0 сая төгрөг, Биологийн хүрээлэн урсгал төсвөөс 787.0 сая төгрөг, Археологийн хүрээлэн урсгал төсвөөс 534.5 сая төгрөг, Одон орон, геофизикийн хүрээлэн урсгал төсвөөс 238.0 сая төгрөг, Палеонтологийн хүрээлэн урсгал төсвөөс 491.2 сая төгрөг, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн урсгал төсвөөс 435 сая төгрөг, Газарзүй, геоэкологийн хүрээлэн өөрийн хөрөнгөөс 85.0 сая төгрөг, нийт 4,922.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барааны 22, ажлын 13, үйлчилгээний 6 тендер төлөвлөж, Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр худалдан авах 943.1 сая төгрөг, урсгал төсвөөс худалдан авах 3,277.9 сая төгрөг, нийт 4,305.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинжлэх Ухааны Академийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн академын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, өр төлбөрийг барагдуулах, цаашид ашиглах боломжтой эд хөрөнгийн үнэ, ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, бараа материалыг зөв ангилж бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Баасанцэнд, аудитор Г.Тэлмүүн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн 4/90 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 55,462.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 554.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 65,760.2 сая төгрөг болж, 2024 оноос 10,297.8 сая төгрөгөөр буюу 18.6 хувиар өссөн нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээг өөрчлөөгүй 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 65,760.2 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож материаллаг байдлын түвшнийг 657.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуваарилагдсан төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, хуульд тусгагдсан хэмнэлтийн горим, бусад арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход анхаарч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдэд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Газарзүй, геоэкологийн хүрээлэн: Шилэн дансны цахим системд 847,377.2 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн;
- Биологийн хүрээлэн: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 128 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,561,510.4 мянган төгрөгийн 28 гүйлгээ, 613,971.3 мянган төгрөгийн зарлагын 38 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнд хийсэн аудитаар бусад хууль тогтоомжийн нийцлийн 1 зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Биологийн хүрээлэн: Худалдан авах төлөвлөгөөний дагуу 9 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл дутуу, тендерийг үнэлэх журмын дагуу маягтуудыг нөхөж үнэлээг хийгээгүй, ТШ-д оролцогчийн санхүүгийн, хүний нөөцийн чадавхийг үнэлэхэд шаардлагатай нотлох баримтууд байхгүй, зарим оролцогч санал болгож буй техникийн тодорхойлолт болон нотлох баримт бичгийг лавлах эх сурвалжийн дагуу ирүүлээгүй байхад шалгаруулсан.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шинжлэх ухааны академийн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийн хэрэгжилт 75.0 хувьтай, түүвэрт хамрагдсан харьяа байгууллагуудад тог тоосон 2 төлбөрийн акт, 8 албан шаардлага, 10 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай, 2 төлбөрийн акт, 9 албан шаардлага, 13 зөвлөмжийн хэрэгжилт 95.8 хувьтай байна.

Хүснэгт 10. Өмнөх аудитын төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төсвийн төвлөрүүлэн захирагч					
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	3	-	2	-	66.7
Дүн	4	-	3	-	75.0
Төсвийн шууд захирагч					
Төлбөрийн акт	2	2,264.0	2	2,264.0	100.0
Албан шаардлага	8	92,755.8	8	92,755.8	100.0
Зөвлөмж	10	87,179.2	10	87,179.2	100.0
Дүн	20	182,199.0	20	182,199.0	100.0
Нийт дүн	24	182,199.0	23	182,199.0	95.8

Өмнөх аудитаар өгсөн харьяа хүрээлэнгүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, тайлант онд гарсан алдаа, зөрчлийн нийт дүнг 20.0 хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллах 1 зөвлөмж өгсөн боловч тайлант онд хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөрчил давтагдан гарсан тул 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Байгууллагын ашигладаг санхүүгийн программ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бүрэн шинэчлэл хийгдсэн эсэх;
- Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар", "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-ыг төсвийн гүйцэтгэл, тайлагналдаа хэрэгжүүлж ажилласан эсэхийг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой **711.3** сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан. Үүнд:

- Газарзүй, геоэкологийн хүрээлэн 706.1 сая төгрөг;
- Физик технологийн хүрээлэн 5.2 сая төгрөг.

Аудитаар нийт 465.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд, 2.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 242.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлага хүргүүлж, 220.9 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 465.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 192.3 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 54.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 54.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлсэн.

5.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Харьяа хүрээлэнгүүдэд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 413.7 саятөгрөгийн 17 зөрчил илэрснээс 2.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 190.8 сая төгрөгийн 10 албан шаардлага хүргүүлж, 220.8 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна. Энэ нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 11.9 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг, 15 дугаар зүйлийн 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, тайлант оны харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нийт дүнг 20.0 хувиар бууруулж дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүллээ.

Илрүүлэлт 2: ШУА-ын ерөнхийлөгчийн 1/122 тоот албан бичгээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан харьяа хүрээлэнгүүдийн санхүүгийн албан хаагчдад 1-2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр балансын урамшуулалд нийт 51.5 сая төгрөгийг тушаалаар олгосон байна.Үүнд:

- Тэргүүлэгчдийн газрын 6 албан хаагчид 27.9 сая төгрөг;
- Археологийн хүрээлэн 2 албан хаагчид 3.9 сая төгрөг;
- Математик, тоон технологийн хүрээлэн 4.3 сая төгрөг;
- Түүх, угсаатны зүйн хүрээлэн 6.3 төгрөг;
- Хэл зохиолын хүрээлэн 2 албан хаагчид 1.9 төгрөг;
- Олон улс судлалын хүрээлэн 1 албан хаагчид 3.1 төгрөг;
- Геологийн хүрээлэн 1 албан хаагчид 3.1 төгрөг;
- Тархи, сэтгэл судлалын хүрээлэн 1.0 мянган төгрөг;
- Филиософийн хүрээлэн 2.7 мянган төгрөг.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд

заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа хүрээлэнгүүдийн санхүүгийн албан хаагчдад үр үнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

Илрүүлэлт 3: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын төсвөөр 3.0 сая төгрөгийн бэлэг дурсгалийн зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бэлэг, дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

5.2 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 17 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 11 байгууллага аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" **6**, дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын нийт 268.9 сая төгрөгийн 13 зөрчил илэрч, 2.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 46.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, 220.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг өгсөн.

5.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Археологийн хүрээлэн нь "Монгол, Байгаль, Өмнөд Сибирь ба Умард Хятадын эртний соёлууд" олон улсын эрдэм шинжилгээний хурлын оролцогчдын байрлах байрны зардлыг харьцуулалтын арга ашиглалгүй шууд худалдан авалтаар 87.6 сая төгрөгийн санхүүжилтийг "Түмэн-Асарт" ХХК-д олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1-р хавсралт "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

Илрүүлэлт 2: Олон улс судлалын хүрээлэн нь тайлант оны 4-р улирлын Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүн бүрэн гараагүй байхад буюу 11 дүгээр сард 19.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараахь эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 2-р зүйлийн 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн

төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүн бүрэн гараагүй байхад үр дүнгийн урамшууллал олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 3: Палеонтологийн хүрээлэн нь шууд худалдан авах аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж 1:5000, 1:10000 масштабтай нарийвчилсан зураг гүйцэтгүүлэх ажлыг Суваргын дэнж ХХК-тай 18.0 сая төгрөг, Геоверс консалтинг ХХК-тай 17.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн шууд захирагч													
1	Газарзүй, геоэкологийн хүрээлэн	2	706,096.6			2	706,096.6	2	706,096.6				
	Физик технологийн хүрээлэн	2	5,200.0			2	5,200.0	2	5,200.0				
	Дүн	4	711,296.6	-	-	4	711,296.6	4	711,296.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
1	Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар	4	54,552.4			3	54,552.4	1	-		
	Дүн	4	54,552.4	0	-	3	54,552.4	1	-	-	-
Төсвийн шууд захирагч											
1	Биологийн хүрээлэн	4	43,166.5	1	2,000.0	1	40,275.5	2	891.0		
2	Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	1	131.9	1	131.9						
3	Газарзүй, геоэкологийн хүрээлэн	2	1,273.2			1	-	1	1,273.2		
4	Одон орон, геофизикийн хүрээлэн	1	2,014.6					1	2,014.6		
5	Физик технологийн хүрээлэн	1	216,667.3					1	216,667.3		
6	Хими, химийн технологийн хүрээлэн	4	5,703.4			4	5,703.4				
7	Археологийн хүрээлэн	1	87,640.0			1	87,640.0				
8	Олон улс судлалын хүрээлэн	1	19,125.7			1	19,125.7				
9	Палентологийн хүрээлэн	1	35,000.0			1	35,000.0				
	Дүн	16	410,722.6	2	2,131.9	9	187,744.6	5	220,846.1	-	-
	Дүн	20	465,275.0	2	2,131.9	12	242,297.0	6	220,846.1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Төсвийн шууд захирагч									
1	Биологийн хүрээлэн	1	5,175,481.7			1	5,175,481.7		
2	Газарзүй, геоэкологийн хүрээлэн	1	847,377.2					1	847,377.2
Дүн		2	6,022,858.9	-	-	1	5,175,481.7	1	847,377.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Төсвийн шууд захирагч									
	Биологийн хүрээлэн	1	-			1	-		
Дүн		1	-	-	-	1	-	-	-
Нийт дүн		3	6,022,858.9	-	-	1	5,175,481.7	1	847,377.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1103/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/14/ИА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох-тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Археологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүрээлэн нь "Монгол, Байгаль, Өмнөд Сибирь ба Умард Хятадын эртний соёлууд" олон улсын эрдэм шинжилгээний хурлын оролцогчдын байрлах байрны зардлыг харьцуулалтын арга ашиглалгүй шууд худалдан авалтаар зохион байгуулж, 87,640,000.00 /Наян долоон сая зургаан зуун дөчин мянган/ төгрөгийн санхүүжилтийг "Түмэн-Асарт" ХХК-д олгосон байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчсөн нь төлбөрийн акт тогтоох үндэслэл бүрдээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Археологийн хүрээлэнгийн захирал /Г.Эрэгзэн/, нягтлан бодогч /Д.Бадамханд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325.SAG-21..Docx

1526181457



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1104/А0170039

Улаанбаатар хот

САГ - 2026/174/КА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Олон улс судлалын хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүрээлэн нь тайлант оны 4 дүгээр улирлын Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүн бүрэн гараагүй байхад буюу 11 дүгээр сард 19,125,720.00 /Арван есөн сая нэг зуун хорин таван мянга долоон зуун хорин/ төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон байна.


Энэ Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,"; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 2-р зүйлийн 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүн бүрэн гараагүй байхад үр дүнгийн урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улс судлалын хүрээлэнгийн захирал /Д.Золбоо/, нягтлан бодогч /Д.Баярмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1105/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/190/НА-СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Палеонтологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүрээлэн нь шууд худалдан авах аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж, 1:5000, 1:10000 масштабтай нарийвчилсан зураг гүйцэтгүүлэх ажлыг "Суваргын дэнж" ХХК-тай 18,000,000.00 /Арван найман сая/ төгрөг, "Геоверс консалтинг" ХХК-тай 17,000,000.00 /Арван долоон сая/ төгрөгөөр гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчсөн нь төлбөрийн акт тогтоох үндэслэл бүрдээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Палеонтологийн хүрээлэн захирагч /З.Бадамхатан/, нягтлан бодогч /Э.Саруул/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1106/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа хүрээлэнгүүдэд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 413,739,553.20 /Дөрвөн зуун арван гурван сая долоон зуун гучин есөн мянга таван зуун тавин гурван төгрөг хорин мөнгө/ төгрөгийн 18 зөрчил илэрснээс 2,131,900.00 /Хоёр сая нэг зуун гучин нэгэн мянга есөн зуун/ төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 190,761,607.00 /Нэг зуун ерэн сая долоон зуун жаран нэгэн мянга зургаан зуун долоон/ төгрөгийн 11 албан шаардлага хүргүүлж, 220,846,046.20 /Хоёр зуун хорин сая найман зуун дөчин зургаан мянга дөчин зургаан төгрөг хорин мөнгө/ төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна. Энэ нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 11,869,653.20 /Арван нэгэн сая найман зуун жаран есөн мянга зургаан зуун тавин гурван төгрөг хорин мөнгө/ төгрөгөөр өссөн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгах, тайлант оны харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нийт дүнг 20.0 хувиар бууруулж дотоод хяналтыг сайжруулах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэргүүлэгчдийн газрын дарга /А.Баярбаатар/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Н.Нямгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Т.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-21-.Docx

1526181463



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1107/А0170039

Улаанбаатар хот

САГ - 2026/19/НА - СТА - ТТЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн 1/122 тоот албан бичгийг үндэслэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан харьяа хүрээлэнгүүдийн санхүүгийн албан хаагчдад 1-2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нийт 51,535,400.00 /Тавин нэгэн сая таван зуун гучин таван мянга дөрвөн зуун/ төгрөгийн балансын урамшуулал олгосон байна. Үүнд:


- Тэргүүлэгчдийн газрын 6 албан хаагчид 27,860,000.00 /Хорин долоон сая найман зуун жаран мянган/ төгрөг;
- Археологийн хүрээлэн 2 албан хаагчид 3,950,000.00 /Гурван сая есөн зуун тавин мянган/ төгрөг;
- Математик, тоон технологийн хүрээлэн 4,270,200.00 /Дөрвөн сая хоёр зуун далан мянга хоёр зуун/ төгрөг;
- Түүх, угсаатны зүйн хүрээлэн 6,295,200.00 /Зургаан сая хоёр зуун ерэн таван мянга хоёр зуун/ төгрөг;
- Хэл зохиолын хүрээлэн 2 албан хаагчид 1,885,000.00 /Нэг сая найман зуун наян таван мянган/ төгрөг;
- Олон улс судлалын хүрээлэн 1 албан хаагчид 3,150,000.00 /Гурван сая нэг зуун тавин мянган/ төгрөг;
- Геологийн хүрээлэн 1 албан хаагчид 3,075,000.00 /Гурван сая далан таван мянган/ төгрөг;
- Тархи, сэтгэл судлалын хүрээлэн 1,050,000.00 /Нэг сая тавин мянган/ төгрөг;
- Филиософийн хүрээлэн 2,700,000.00 /Хоёр сая долоон зуун мянган/ төгрөг.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа хүрээлэнгүүдийн санхүүгийн албан хаагчдад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэргүүлэгчдийн газрын дарга /А.Баярбаатар/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Н.Нямгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Талчиг хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-21_1.Docx

1526181465



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1108/АД170039

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА - СТА - ТТЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухааны академийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын төсвөөр 3,017,000.00 /Гурван сая арван долоон мянган/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бэлэг, дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэргүүлэгчдийн газрын дарга /А.Баярбаатар/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Н.Нямгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН